


ШАШНЫ ЭРХ ЧӨЛӨӨ

*Таны эрхийн тухай
удирдамж*

МОНГОЛ



*“Хүн бүр чөлөөтэй бодож
сэтгэх, шашин шүтэх,
эс шүтэх эрхтэй. Энэхүү
эрхэнд шашин буюу
шүтлэгээ өөрчлөх эрх
чөлөө, бие даан буюу
бусадтай хамтран
нийтийн өмнө болон
хувийн журмаар хичээл
заах, хурал мөргөл
хийх, шашны хийгээд
зан үйлийн ёслол үйлдэх
зэргээр шашин буюу
шүтлэгээ номлох эрх
чөлөө багтана.”*

*—Хүний эрхийн түгээмэл
тунхаглал, 18-р зүйл*

МОНГОЛ ДАХЬ ШАШНЫ БОЛОН ШҮТЭН БИШРЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

1. Шашны болон шүтэн бишрэх эрх чөлөө гэж юу вэ?

Монгол Улсын Үндсэн хуулиар иргэд чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх, тэр дундаа бодол санаа, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй гэж заадаг. Энэ нь хувь хүн шашинд нэгдэх, хүлээн авах мөн шашнаа өөрчлөх, татгалзах эрхийг тусгасан байдаг. Үүнд ганцаараа болон бүлгээрээ шашин, итгэл үнэмшлээ шүтэх эрх чөлөө багтана. Энэ нь хүмүүсийг өөрсдийн сонгосон шашны үзэл бодол, итгэл үнэмшлээсээ болж гадуурхагдах, доромжлогдохоос хамгаалдаг.

2. Итгэх, чөлөөтэй бодож сэтгэх эрх чөлөө гэж юу вэ?

Монгол Улсад хувь хүн бусдын итгэл үнэмшил, үзэл бодлоос үл хамааран өөрийн итгэл үнэмшил, баримт, үзэл бодол, бодол санааг баримтлах, авч үзэх хууль ёсны эрхтэй. Монгол Улсын хууль тогтоомж нь тухайн хүн бусдын хөндлөнгийн оролцоогүйгээр итгэл үнэмшилтэй байх, эс байх эрхээ эдлэх эрхийг дэмждэг бөгөөд энэ нь ялгаварлан гадуурхах үндэслэл болох ёсгүй.

3. Шашны эрх чөлөөг хамгаалдаг ямар ямар хууль тогтоомж байдаг вэ?

Монгол Улсын дараах хууль тогтоомжууд шашин шүтэх, эс шүтэх эрхийг хамгаалдаг. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 16.15, 16.16
- Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 1, 3 дугаар зүйл
- Эрүүгийн хуулийн 14.4.1

- Зөрчлийн тухай хуулийн 15.22.1
- Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.

4. Монгол улсын албан ёсны шашин юу вэ?

Монголд төрийн шашин гэж байдаггүй ч улс орны хамгийн том шашны байгууллага болох Буддын шашныг төр “илүү дээдэлдэг”. Энэ давуу байдал нь хувь хүмүүсийн бусад шашныг шүтэх эрхэд саад болдоггүй.

5. Миний шашин шүтэх эрх зөрчигдвөл би яах вэ?

Иргэд эрх нь зөрчигдсөн гэж үзвэл дараах байгууллагад хандаж тусламж хүсэж болно. Тухайлбал:

- Цагдаагийн газар. Цагдаагийн газар гомдлыг хүлээн авч, хууль зөрчсөн тохиолдолд торгууль ногдуулдаг. Хууль бус үйлдэл нь хуульд заасанчлан гэмт хэргийн шинж чанартай байвал эрүүгийн хэрэг үүсгэж болно.
- Шүүх. Прокурор яллах дүгнэлт гаргавал хэргийг харьяа шүүхэд шилжүүлж, шүүхийн системээр шийдвэрлэнэ. Шүүхийн шийдвэрийг холбогдох бүх хүн заавал дагаж мөрдөх ёстой.
- Хүний эрхийн комисс. Хүний эрхийн комисс нь гомдлыг бичгээр болон аман хэлбэрээр хүлээн авсныхаа дараа хянан үзэж, зөрчлийн тухай дүгнэлт гаргаж болно.

ШАШИН БА ОЛОН НИЙТИЙН ГАЗАР

6. Би шашны үзэл бодлоо олон нийтэд илэрхийлж болох уу?

Болно. Монгол Улсын Үндсэн хуулийн 15.15, 16.16-д иргэн бүр “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй”, “Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй” гэж заасан байдаг. Төр, сүм хийдийн

харилцааны тухай хуулийн 7.3-д шашны үзэл бодлоо илэрхийлж, шашны зан үйлийг хувийн болон олон нийтийн газар чөлөөтэй үйлдэж болох ч нийтийн хурал цуглаан, жагсаал хийх бол мэдэгдлээ холбогдох төрийн байгууллагад танилцуулж зөвшөөрөл авах ёстой болохыг тусгасан. Нисэх буудал, төмөр зам, тээврийн цэгүүд, цэрэг, цагдаа, төрийн хамгаалалтад байгаа газар нутаг, хот суурин газрын хүнс, барааны зах, болон эмнэлгийн байгууллагууд гэх мэт газруудад тодорхой үйл ажиллагаа, үүнд олон нийтийн хурал, жагсаал цуглаан хийхийг хуулиар хориглосон.

7. Би бусадтай итгэл үнэмшилээ хуваалцаж эсвэл номлож болох уу?

Болно. Монгол Улсын хууль нь нийтэд болон хувийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг олгохын зэрэгцээ шашны итгэл үнэмшил, үзэл бодол, бодол санаа, саналаа бусадтай хуваалцах боломжийг олгодог. Шашин шүтэх эрх чөлөө гагцхүү бусдын эрх чөлөө, эрүүл мэнд, ёс суртахууны хэм хэмжээ, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг сахиулах тухай Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу хэрэгжинэ.

8. Би шашны нэгж, байгууллагын нэг хэсэг байж болох уу?

Болно. Монгол Улсын Үндсэн хуулийн 16.10-д нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс олон нийтийн байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй гэж заасан байдаг. Энэ эрхт шашны зорилгоор мөргөл, цуглаан хийх газар байгуулах, дотоод журам, шатлан захирах эрх зэрэг багтана. Хувь хүмүүс мөн Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа тохиолдолд теологийн судалгаа хийж болно. Монгол Улсын хууль тогтоомжид хүнийг олон нийтийн холбоонд элссэн, аливаа шашны бүлгийн гишүүнийх нь төлөө гадуурхах, хавчихыг хориглодог.

9. Шашны байгууллагыг зохицуулдаг төрийн байгууллагууд юу вэ?

Монголд шашны бүх байгууллага, үйл ажиллагааг хянадаг төрийн нэгдсэн байгууллага байдаггүй. Гэхдээ төр шашны байгууллагыг дараах байдлаар зохицуулдаг.

- Шашин, сүм хийдийн талаар төрөөс баримтлах бодлогыг УИХ тодорхойлдог.
- Ерөнхийлөгч төр, сүм хийд, шашин хоорондын харилцааг үндэсний эв нэгдэл, аюулгүй байдалд нийцүүлэн зохицуулдаг.
- Төрийн захиргааны алба, аймаг (муж), нийслэлийн Засаг дарга төр, шашны байгууллагуудын хоорондын харилцааг хянадаг.
- Аймаг, нийслэлийн ИТХ (нутгийн өөрөө удирдах байгууллага) сүм хийд байгуулах тухай шашны байгууллагаас ирүүлсэн өргөдлийг хэлэлцэн, хүсэлт гаргасан байгууллагад зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэдэг.
- Улсын бүртгэлийн ерөнхий газар олгосон зөвшөөрлийн үндсэн дээр сүм хийдийг бүртгэдэг.

АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ШАШНЫ ЭРХ ЧӨЛӨӨ

10. Шашин шүтэх эрх чөлөө нь ажил олгогч, ажилтны хоорондын харилцаанд ямар нөлөө үзүүлдэг вэ?

Үндсэн хууль болон хөдөлмөрийн харилцааг зохицуулдаг хуулиудад шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахыг хориглодог. Ажилтны шашны итгэл үнэмшил нь хөдөлмөрийн харилцаанд нөлөөлөх ёсгүй, үүнд цалин хөлс тогтоох, хөдөлмөрийн гэрээг цуцлах, ажилтны аливаа эрхийг хасах, ажлын байран дахь шударга бус хандлага зэрэг орно.

11. Шашны эрх чөлөө, хөдөлмөрийн цаг хоёр ямар хамааралтай вэ?

2022 оны Хөдөлмөрийн тухай хуулийн 96.1, 97.1-д заасны дагуу бямба, ням гараг, нийтээр амрах бүх өдөр ажиллахгүй байх эрхтэй. Монголд шашны бүх нийтийн амралтын нэг жишээ бол билгийн тооллын зуны тэргүүн сарын шинийн арван тавны өдөр буюу Буддагийн их дүйчин өдөр юм.

12. Би ажилдаа шашны хувцас өмсөж болох уу, эсвэл шашны итгэл үнэмшлээсээ болж зарим дүрэмт хувцсыг өмсөхөөс татгалзаж болох уу?

Үндсэн хууль болон Хөдөлмөрийн тухай хуулийн 6.1-д шашин шүтлэгээр нь хэнийг ч ялгаварлан гадуурхахыг хориглодог. Тиймээс үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэхийн тулд дүрэмт хувцас өмсөх зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд ажилчид энэ асуудлыг ажил олгогчтойгоо ярилцах ёстой.

СУРГУУЛЬ ДАХЬ ШАШНЫ ЭРХ ЧӨЛӨӨ

13. Улсын сургуулиудад шашны хичээл орж болох уу?

Үгүй ээ. Улсын сургуульд шашны хичээл явуулахыг хориглосон ч Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 8.2-т шашны соёл, мэдлэг ухааны өв уламжлалын тухай шинжлэх ухааны сургалт явуулах боломжтой. Зөрчлийн тухай хуулийн 15.22.1-д зааснаар төрийн өмчийн сургуульд шашны хичээл, цуглаан зохион байгуулсан иргэнийг 300 мянган төгрөгөөр, зохион байгуулагч хуулийн этгээдийг гурван сая төгрөгөөр тус тус торгоно.

14. Оюутнууд сургуульдаа шашны боловсрол, шашны зан үйлд заавал хамрагдах ёстой юу?

Үгүй ээ. Шашны боловсролыг зөвхөн шашны сургууль, гэрийн сургалтаар дамжуулан олгодог. Улсын сургуулиудад шашны хичээл, цуглаан зохион байгуулахыг хориглодог бөгөөд ийм үйлдэлд хуулийн хариуцлага хүлээлгэдэг. Гэхдээ оюутан суралцагчдад шашны соёлын тухай түүх, шинжлэх ухааны судалгаа, мэдлэг ухааны өв уламжлал гэх мэт цэвэр академик хөтөлбөрөөр шашны талаар суралцахыг нь хориглодоггүй.

15. Оюутан суралцагчид шашны итгэл үнэмшлийнхээ улмаас сургууль, сургуулийн хуваарьт үйл ажиллагаанд оролцохоос татгалзаж болох уу?

Ерөнхийдөө энэ асуудал Монгол Улсын боловсролын тухай хуульд тусгагдаагүй боловч боловсролын байгууллага дотоод дүрэм журмаараа үүнийг зохицуулдаг. Шашны итгэл үнэмшилд нь харш үйл ажиллагаа явуулж байвал эцэг эх нь уг үйл ажиллагаанд оролцохоос татгалзах хүсэлт гаргаж болно.

16. Оюутан суралцагчид шашны итгэл үнэмшлээсээ болоод сургуулийн дүрэмт хувцсаа өөрчилж болох уу?

Шашны итгэл үнэмшилд суурилсан дүрэмт хувцасны шаардлага, өөрчлөлтийг сургуулийн бодлогоор тогтоодог. Шашны эрх чөлөөг хүндэлж, итгэл үнэмшлээр нь ялгаварлан гадуурхахыг хориглох үүднээс сургууль нь бүгдийг тэгш хамруулан сургах бодлогыг эрхэмлэх ёстой. Оюутан сурагч нь дүрэмт хувцсанд өөрчлөлт оруулах зөвшөөрөл авах хүсэлтээ сургуулийн захиргаанд өгөх ёстой.

ЦЭРГИЙН БОЛОН НИЙТИЙН АЛБА

17. Цэргийн алба хаах, нийтийн албанд заавал ажиллах ёстой юу? Хэрэв тийм бол шашны үндэслэлээр чөлөөлдөг үү?

Тийм ээ. 18-25 насны эрэгтэйчүүд 12 сар цэргийн алба хаах үүрэгтэй бөгөөд шашин шүтлэг, итгэл үнэмшлээр нь ялгаварлан гадуурхаж болохгүй. Харин Цэргийн албаны тухай хуулийн 16.1.2-т иргэн 24 сар цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаах юм бол хугацаат цэргийн албанаас чөлөөлж болно гэж заасан байдаг. Тухайн иргэнтэй Цэргийн дүйцүүлэх алба хаах тухай гэрээ байгуулж, тухайн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб биелэлтийг дүгнэнэ. Дүйцүүлэх албанд хамрагдаж нийтийн албанд үйлчилж буй эрэгтэйчүүдийг гамшгаас хамгаалах, хил орчмыг дэглэмийг сахиулах, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцуулж болох бөгөөд аймаг, нийслэл, дүүргийн Цэргийн штабаас томилно.

ШАШИН БА ШУДАРГА ЁС

18. Би шашны итгэл үнэмшлээсээ болж шүүх хуралдааны үеэр тангараг өргөхөөс татгалзаж болох уу?

Шүүх хуралдаанд оролцогчид үнэнийг хэлэх үүрэгтэй ч шүүх хуралдаанд оролцогчид, тэр дундаа гэрч, орчуулагч, нэхэмжлэгч талууд тангараг өргөдөггүй. Үүний оронд тэд шүүх хуралдааны явцад хуулиар хүлээсэн эрх, үүргийг нь сануулсан бичигт гарын үсэг зурдаг.

19. Шүүгчид өөрсдийн шашны итгэл үнэмшлээрээ шийдвэр гаргаж болох уу?

Болохгүй. Шүүхийн шийдвэр нь зөвхөн хуулийг дээдлэх зарчимд суурилсан байх ёстой. Шүүгчийн бүх үүргийг арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, бусад үндэслэлээр ялгаварлан гадуурхахгүйгээр гүйцэтгэх ёстой. Шүүх нь тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндсэн хуулийн дэг журмыг бэхжүүлэх, хамгаалах; хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээх; хуулиа дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх; иргэдийн шударга шүүхээр шүүгдэх эрхийг хангах үүрэгтэй.

20. Шашны удирдагчдад өгсөн мэдэгдлийн нууцыг хадгалах ямар нэгэн хамгаалалт байдаг уу?

Монгол Улсын хуульд шашны удирдагчдад өгсөн мэдэгдлийн нууцыг хамгаалах тусгайлсан заалт байдаггүй. Харин Хувь хүний нууцын тухай хуулийн 2, 4.1-д Монгол Улсад байгаа хүний нууцыг хамгаалдаг. Энэхүү нууц мэдээллийг “Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ” гэж тодорхойлсон. Үүнд захидал харилцааны, эрүүл мэндийн, хөрөнгийн, гэр бүлийн болон хуулиар тогтоосон бусад нууц багтана. Шашны удирдагчдад хэлсэн нууц мэдэгдлийг дээрх хувь хүний нууцын нэг төрөл гэж үзэж болно.

ШАШНЫ ЭРХ ЧӨЛӨӨ ОЛОН УЛСЫН ХУУЛЬД

Улс орнууд шашин шүтэх эрх чөлөөг орон нутгийн түвшинд хамгаалахаас гадна энэ эрхийг хамгаалсан олон улсын янз бүрийн хууль, эрх зүйн баримт бичиг байдаг. 1948 онд шашин шүтэх, чөлөөтэй бодож сэтгэх эрх чөлөө гэх ойлголтыг Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар танилцуулсан. Түүнээс хойш энэ эрхийг олон улсын түвшинд тогтоож, хөгжүүлсэн өөр өөр гэрээ, конвенцууд гарч ирсэн.

Олон улсын хуулийн дагуу надад ямар ямар хамгаалалт байгаа вэ?

Олон улсын баримт бичгүүдэд шашин шүтлэгээс үл хамааран бүх хүн хуулийн өмнө тэгш эрхтэй гэдгийг цохон тэмдэглэсэн. Мөн эдгээр хуульд хэнийг ч шашин шүтлэгт нь үндэслэн ялгаварлан гадуурхаж болохгүй гэдгийг заасан байдаг. Энэ нь хүний нэр төрд халдсан гэмт хэрэг бөгөөд хүний эрх, үндсэн эрх чөлөөг зөрчсөн үйлдэл гэж буруушаадаг.

Эдгээр олон улсын баримт бичигт ямар ямар эрх чөлөөг тусгасан байдаг вэ?

- **Өөрийн үзэл бодолтой байх, чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх эрх чөлөө.**

Энэхүү эрх чөлөөнд бүх асуудлаар өөрийн үзэл бодолтой байх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтлэг, итгэл үнэмшлээ баримтлах, хувь хүний итгэл үнэмшлийн эрх чөлөө зэрэг багтана. Энэ нь өөрийн сонгосон шашин, итгэл үнэмшилтэй байх, шашин, итгэл үнэмшлийг хүлээн авах эрх чөлөөг хязгаарладаггүй. Хэний ч бодол санаа, шашин шүтлэг, итгэл үнэмшлийг нь албадан илчлүүлэх ёсгүй.

- **Шашин, итгэл үнэмшлээ өөрчлөх эрх чөлөө.**

Бүх хүн өөрсдийн шашин шүтлэг, итгэл үнэмшлээ орхиж, өөр шашин шүтэх, эсвэл ямар ч итгэл үнэмшилгүй байх эрхтэй. Хувь хүний тодорхой шашин, итгэл үнэмшлийг хүлээн авах, өөрчлөх, хадгалан үлдэхийг албадах зорилгоор биеийн хүч хэрэглэх, шийтгэл оногдуулах, бодлого баримтлах, үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

- **Өөрийн шашин шүтлэг, итгэл үнэмшлийг ганцаараа болон хамтаар олон нийтэд болон хувийн шугамаар илэрхийлэх, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө.**

Хүн бүр төрийн болон шашны байгууллагаас зөвшөөрөл авалгүйгээр өөрийн шашин, итгэл үнэмшлийг бусадтай тайван замаар түгээн дэлгэрүүлэх, хуваалцах эрхтэй. Энэ эрх нь зөвхөн бүртгэлтэй шашны нийгэмлэгийн гишүүдэд хамаарахгүй. Түүнчлэн шашны нийгэмлэг, байгууллага эрхээ эдлэхийн тулд заавал бүртгүүлэх ёсгүй.

- **Сургаал заах, зан үйл болон мөргөл үйлдэх замаар шашин шүтэх эрх чөлөө.**

Шүтлэг, ёс дэгийг сахих, зан үйл үйлдэх, сургаал заах замаар шашин, итгэл үнэмшлээ илэрхийлэх эрх чөлөө нь өргөн хүрээтэй.

- Шүтэн бишрэх, зан үйлийг сахихад итгэл үнэмшлээ шууд илэрхийлэх ёс дэгээс гадна мөргөлийн газар барих, зан үйлийг томъёолох, тахилын эд зүйлс ашиглах, бэлгэдлийг харуулах, баяр ёслол, амралтын өдрүүдийг тэмдэглэх зэрэг олон төрлийн зан үйлийг хамардаг.
- Шашин, итгэл үнэмшлээ дагах, заахад шашны бүлгүүд өөрсдийн шашны удирдагч, санваартан, багш нараа сонгох, шашны семинар, сургууль байгуулах, шашин шүтлэг, итгэл үнэмшлээ зааж, сургах ном зохиол, хэвлэл бэлтгэх, түгээх эрх чөлөө зэрэг үндсэн үйл ажиллагаагаа явуулахтай салшгүй холбоотой ажил хэргүүд багтана.

- **Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхэд, сурагчдаа өөрсдийн итгэл үнэмшилд нийцүүлэн шашны болон ёс суртахууны боловсрол эзэмшүүлэх эрх чөлөө.**

Хүүхдүүд эцэг эх, асран хамгаалагчийнхаа хүсэл, шашин шүтлэг, итгэл үнэмшлийн дагуу шашны боловсрол эзэмших эрхтэй. Үүний нэгэн адил хүүхдүүдийг эцэг эх, асран хамгаалагчийнх нь хүсэлд харшлах шашны сургаалд албадан оруулах ёсгүй. Хүүхдийн ашиг сонирхлыг дээдлэх зарчмын дагуу төр нь сургуулиудад шашны хүлцэнгүй үзлийг баримталж, олон ургалч үзэл, төрөл бүрийн шашныг хүндэтгэх үзлийг дэмжих ёстой.

Эдгээр эрх чөлөөнд ямар нэгэн хязгаарлалт бий юу?

Байгаа. Нийтийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн зарим хязгаарлалтыг хуульд заасан байдаг. Гэсэн хэдий ч хязгаарлалтыг ялгаварлан гадуурхах зорилгоор эсвэл ялгаварлан гадуурхах байдлаар тавьж болохгүй.

НИЙТЛЭГ ОЙЛГОЛТЫГ ОЛОХ

Хүмүүс бид өөрсдийн итгэл үнэмшлээ сонгох, хуваалцах, үүнийхээ дагуу амьдрах эрх чөлөөтэй. Бид ерөнхийдөө шашны эрх чөлөө, итгэл үнэмшлээ нандигнан, амьдралдаа баримтлахыг эрхэмлэдэг. Бид өөрсдийн шашин шүтлэг, итгэл үнэмшлийг эрхэмлэдгийн нэгэн адил бүх хүний шашин шүтэх эрх чөлөө, итгэл үнэмшлийг эрхэмлэн дээдлэх ёстой. Эдгээр эрх чөлөөний ач холбогдлыг мэддэг хүний хувиар бид шашин шүтэх эрх чөлөөний зарчмуудыг нийтэд хэрхэн түгээж болох вэ? Өөр өөр итгэл үнэмшилтэй хүмүүстэй харилцахдаа нийтлэг нэг ойлголтод хүрэх арга зам бий юу?

Дараах стратеги нь орон нутгийнхаа хүрээнд нэг ойлголтод хүрэх боломжийг танд олгож болох юм. Үүнд:

МЭДЛЭГЭЭ ТЭЛЭХ

Та өөрийн болон бусдын шашны итгэл үнэмшлийг хамгаалахын өмнө шашин шүтэх эрх, эрх чөлөөний үндсэн зарчмуудыг мэдэж, мэдлэгтэй болох нь чухал юм. Энэхүү товхимолд таны үндсэн эрх, шашин шүтэх эрх чөлөөтэй холбоотой зарим мэдээлэл багтсан болно. Мэдээнээс эдгээр эрх чөлөөнд нөлөөлөх үйл явдлуудыг харж, шашны эрх чөлөөнд гарсан өөрчлөлтүүдийн талаар мэдээлэлтэй байхыг эрэлхийл.

БҮХ ТАЛЫГ СОНС

Бусад хүмүүсийн шашин шүтлэг, чин сэтгэлийн итгэл үнэмшлийг сонсож, ач холбогдол өгч байгаагаа харуул. Хэдийгээр та бусдын итгэл үнэмшилтэй санал нийлэхгүй байсан ч тухайн хүний үзэл бодлыг ойлгож, хүндэтгэхийг нэн тэргүүнд тавь. Хүмүүсийн үг, итгэл үнэмшил, үйлдэлд олон хүчин зүйл нөлөөлдөг. Та өөрийн байр суурийг тайлбарлаж, баримтлахдаа бусдын бодол санаанд болгоомжтой хандаж, чин сэтгэлийн итгэл үнэмшлээс маань болж дайрч доромжлохгүй байхыг хүсэх хэрэгтэй.

СОЁЛТОЙ БОЛОВСОН БАЙХ

Үзэл бодол, итгэл үнэмшлийн зөрүүтэй нийгэмд амьдрахын тулд юуны талаар мэтгэлцэх нь чухал бус харин хэрхэн мэтгэлцэхээ мэдэх нь чухал. Маргаантай сэдвүүдийн талаарх таны яриа хэрүүл маргааны өнгө аястай байх ёсгүй. Бүх хүн үнэн зөв, шударга байхыг эрхэмлэхийн зэрэгцээ бие биедээ соёлтой боловсон, хүндлэлтэй хандах ёстой. Та байр сууриа хүргэж чадаагүй бол таагүй үр дүнг эелдэг, соёлтойгоор хүлээж авах хэрэгтэй. Арьс өнгө, үндэс угсаа, шашны итгэл үнэмшилтэй мөн итгэл үнэмшилгүй байх, бэлгийн чиг баримжаа зэргээс шалтгаалан хавчин гадуурхах зэрэг аливаа төрлийн хавчлагаас татгалзах нь зүйтэй гэдгийг бүү мартаарай.

ХҮЛЭЭЦТЭЙ БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭХ

Хүмүүс санал нийлэхгүй байсан ч эв найртай зэрэгцэн амьдрах чадвартай байх ёстой. Амар тайван амьдарна гэдэг үзэл бодлоосоо ухрах гэсэн үг биш. Энэ нь харин таны үнэт зүйлсийг хуваалцдаггүй эсвэл тэдгээрийн суурь сургаалыг хүлээн зөвшөөрдөггүй бусадтай тайван амьдрахыг хичээх хэрэгтэй гэсэн үг юм. Бусдыг танаас зай барихад хүргэлгүйгээр эсвэл бусдыг үл хүндэтгэхгүйгээр үнэт зүйл, хэм хэмжээгээ эргэн тойрныхоо хүмүүст зааж сургахыг хичээ.

БУСДЫН ИТГЭЛ ХҮНДЛЭЛИЙГ ХҮЛЭЭСЭН ХАРИЛЦАА ХОЛБООГ ҮҮСГЭ

Орон нутагтаа олон янзын үзэл бодолтой хүмүүсийн дунд бусдын итгэл хүндлэлийг олсон харилцаа холбоо үүсгэ. Хэдий чинээ олон хүнтэй танилцаж, мөн тухайн хүмүүс тань нэг нэгнийхээ итгэл үнэмшлийг ойлгодог болохын хэрээр та бусдад ашигтай байдлаар тэдний эрхийг илүү сайн хамгаалж чадна. Хөршүүд болон иргэдтэй санал нийлж байгаа зүйлс дээрээ төвлөр. Дараа нь хамтран ажиллахдаа шашин шүтлэг, шашин шүтэх эрх чөлөөний ач холбогдлын төлөө дуугараарай.



GO-HRE | GENEVA OFFICE FOR HUMAN RIGHTS EDUCATION



BYU
MANAGEMENT
SOCIETY

